

2014

..... танаа

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

Албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн
2014 оны 1-р улирлын танилцуулга

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Жил бүрийн эхний улирлын байдлаар

	Хэмжих нэгж	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Суурин хүн ам	Тоо	28577	25875	26905	27036	27440	27936	
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	136	179	162	141	145	185	197
Нас баралт	Тоо	45	40	36	45	35	51	45
Шилжиж ирсэн	Тоо	160	225	379	196	207	289	253
Шилжиж явсан	Тоо	191	298	405	215	272	330	282
Ажилгүйчүүд	Тоо	326	494	791	570	405	357	256
Халдварт өвчин	Тоо	131	151	124	170	130	181	82
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	58	69	72	48	74	71	68


АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2014 оны эхний улирлын байдлаар 27.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7.5 хувиар буюу 1.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2013 он	2014 он	өсөлт бууралт	2013 он	2014 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт /мян.тн/	1170.1	1149.2	-20.9	23987050.0	25857000.0	1869950.0
Дулаан дамжуулалт /мян.гкал/	67.8	68.5	0.7	1282031.3	1293473.5	11442.2
Талх үйлдвэрлэлт /тонн/	15.2	18.1	2.9	19069.0	23267.3	4198.3
Нарийн боов үйлдвэрлэлт /тонн/	27.6	35.7	8.1	76701.6	92662.7	15961.1


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дулаан дамжуулалт 1.0 хувиар буюу 0.7 мянган гкал-аар, талх үйлдвэрлэлт 19.1 хувиар буюу 2.9 тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 29.3 хувиар буюу 8.1 тонноор тус тус өссөн бол, нүүрс олборлолт 1.8 хувиар буюу 20.9 мянган тонноор буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1. Нүүрс олборлолт /сараар/



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт үнийн дүнгээрээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж авч үзэхэд нүүрс олборлолт 7.8 хувиар буюу 1869.9 сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 0.9 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 22.0 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 20.8 хувиар буюу 15.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 2. Нүүрс олборлолт /мян.тонн/



Зураг 3. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, тонн



МАЛ АЖ АХУЙ: 2014 оны эхний улирлын байдлаар 14816 эх мал төллөж 14816 төл гарснаас 214 толгой төл мал хорогдсон байна. Энэ нь нийт гарсан төлийн 1.4 хувийг эзэлж байна. Одоогоор 14602 төл мал бойжиж байгаа ба төл бойжилт 98.5%-тай байна. Мал тооллогын дүнгээр энэ онд 54890 толгой төллөх насны хээлтэгч төллөхөөс 14816 эх мал төллөсөн байгаа нь 27.0%-тай байна.

Хүснэгт 3. Том малын зүй бус хорогдол

	Нийт хорогдол	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1 хороо	40	-	-	5	15	20
2 хороо	-	-	-	-	-	-
3 хороо	32	-	2	8	9	13
4 хороо	60	-	8		22	30
5 хороо	155	-	17	23	51	64
ДҮН	287	-	27	36	97	127

Тайлант хугацаанд зүй бусаар хорогдсон 287 толгой том мал байгаагаас 84 толгой нь хээлтэгч мал байна. Нийт хорогдсон мал нь өнгөрсөн онд тоологдсон нийт малын 0.2 хувийг эзэлж байна. Нийт хорогдсон том малаас 132 толгой мал өвчнөөр хорогдсон байна.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: 2014 оны эхний улирлын байдлаар нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 308.6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр буурсан байна. Мөн нийт орлогын 158.8 сая төгрөг буюу 51.4 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 4. Орон сууц нийтийн аж ахуйн орлого зарлагын байдал мянган төгрөг

Үзүүлэлт	2013 он	2014 он	Өөрчлөлт
Орон сууц	94904.8	90576.4	-4328.4
Ус борлуулалт-бүгд	108753.5	109968.3	1214.8
үүнээс: хүн амд	68665.6	70704.8	2039.2
аж ахуйн нэгжид	38254.4	38109.9	-144.5
үйлчилгээний байгууллагад	1833.5	1153.6	-679.9
Сувагжуулалт	99765.7	100132.4	366.7
Бусад	6433.9	7924.2	1490.3
Дүн	309857.9	308601.4	-1256.5

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: 2014 оны эхний улирлын байдлаар дүүргийн СӨХ-дын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.


Хүснэгт 5. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	15620.8	14690.3	94.0
Маргад өргөө	13470.0	11917.9	88.5
Сод хөгжил	12190.4	16241.9	133.2
Шинэ элч	14216.8	12129.4	85.3
Уурхайчин	10752.0	8891.4	82.7
НИЙТ ДҮН	66250.0	63870.9	96.7

НИЙГМИЙН ДААТГАЛ: 2014 оны эхний улирлын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 2288.8 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 11.0 хувиар буюу 225.3 сая төгрөгөөр, зарлага 3986.1 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.2 хувиар буюу 555.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 61.3 хувь буюу 1404.1 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 6.8 хувь буюу 157.1 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 1.8 хувь буюу 38.6 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас, 10.8 хувь буюу 247.3 сая төгрөгийг ҮОМШӨ-ний сангаас, 19.3 хувь буюу 428.2 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас төвлөрсөн байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн бүрдэл




Хүснэгт 6. Нийгмийн даатгалын сан

Үзүүлэлт	Гүйцэтгэл			
	2013 он		2014 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого		2063.5		2288.8
үүнээс: тэтгэврийн сан		1286.2		1404.1
тэтгэмжийн сан		145.0		157.1
ажилгүйдлийн сан		35.6		38.6
ҮОМШӨ-ний сан		168.6		247.3
ЭМД-ын сан		428.2		441.7
Сангийн зарлага	31265	3430.7	24366	3986.1
үүнээс: тэтгэврийн сан	3228	2233.2	3457	2574.2
тэтгэмжийн сан	649	125.7	693	165.7
ажилгүйдлийн сан	47	39.8	51	41.3
ҮОМШӨ-ний сан	571	454.0	465	435.7
ЭМД-ын сан	26773	578.0	19700	769.2

Нийгмийн даатгалын сангаас 3457 хүнд 2574.2 сая төгрөгийн тэтгэвэр, 693 хүнд 165.7 сая төгрөгийн тэтгэмж, 465 хүнд 435.7 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчиний тэтгэмж, 19700 хүнд 769.2 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 51 хүнд 41.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2014 оны эхний улирлын байдлаар нийгмийн халамжийн сангийн 38.4 хувь нь улсын төсвөөс, 61.5 хувь нь орон нутгийн төсвөөс, 0.1 хувь нь бусад орлогоос санхүүжигдсэн байна.

Нийгмийн халамжийн сангаас нийт 684.9 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувь буюу 4.8 сая төгрөгөөр буурсан байна.



Зураг 5. Нийт орлого - 776.6 сая төгрөг

Хүснэгт 7. Нийгмийн халамжийн сан

Үзүүлэлт	Гүйцэтгэл				
	2013 он		2014 он		
	Мян төг	Хүний тоо	Мян төг	Хүний тоо	
Нийгмийн халамжийн сангийн орлого	681806.1		776662.0		
Үүнээс	Улсын төсвөөс	239200.0	298600.0		
	орон нутгийн төсвөөс	425457.8	477795.0		
	Хүний хөгжил сангийн санхүүжилт	15000.0	-		
	бусад орлого	2148.3	267.0		
	Нийгмийн халамжийн сангийн зарлага	689840.8		684981.3	
Үүнээс	Тэтгэвэр	140921.9	544	187210.2	537
	Тэтгэмж	117145.6	349	66852.4	348
	Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	93417.7	890	90680.4	775
	"Хүний хөгжил" сан	21801.9	25	-	-
	"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	147000.0	735	140800.0	704
	"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	116700.0	1167	114300.0	1143
	Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	25303.0	1551	50483.0	1896
	Ахмад дайчин, гавъяатын нэмэгдэл	11650.0	22	10769.6	20
	ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	13465.5	31	10365.1	88
	ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ	447.8	257	9102.0	537
	Бусад үйлчилгээ	1987.4		4418.6	

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 537 хүнд 187.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 348 хүнд 66.8 сая төгрөгийн тэтгэмж, "Алдарт эх"-ийн одонтой 1847 эхчүүдэд 255.1 сая төгрөг, 1896 ахмад настанд 50.5 сая төгрөгийн хөнгөлөлт, 88 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 10.4 сая төгрөгийн хөнгөлөлт, 20 ахмад дайчинд 10.7 сая төгрөгийн нэмэгдэл, олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 537 хүнд 9.1 сая төгрөгийг тус тус олгосон байна.

ТЭЭВЭР: 2014 оны эхний улирлын байдлаар тээврийн салбарын нийт орлого 223.7 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 38.0 хувиар буюу 64.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Тээврийн салбарын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2013 он	2014 он	өсөлт бууралт
Нийт орлого \мян төг\	169366.6	233675.3	64308.7
Тээсэн зорчигч \мян хүн\	45.1	55.0	9.9
Зорчигч эргэлт \мян хүн км/	6090.5	7418.3	1327.8

Тайлант хугацаанд автотээврээр 55.0 мянган зорчигч тээвэрлэж, 7418.3 мянган хүн километрийн ажил үйлчилгээ гүйцэтгэж, 233.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өнгөрсөн оноос мөн үеэс зорчигч эргэлт 21.8 хувиар буюу 1327.8 мянган хүн километрээр, зорчигчдын тоо 22.0 хувиар буюу 9.9 мянган хүнээр тус тус нэмэгджээ.

ШУУДАН ХОЛБОО: Шуудан холбооны үйлчилгээний орлого 2014 оны эхний улиралд 122268.3 мянган төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиар буюу 375.0 мянган төгрөгөөр буурсан бол хүн амаас орсон орлого 64404.3 мянган төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.4 хувиар буюу 1530.9 мянган төгрөгөөр нэмэгджээ. Нийт орлогын 52.7 хувийг хүн амаас оруулсан орлого эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 6 . Шуудан, холбооны үйл илгээний орлого, сая төгрөг



Хүснэгт 9. Холбооны салбарын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2013 он	2014 он	өсөлт бууралт
Нийт орлого	122643.3	122268.3	-375.0
Үүнээс: хүн амаас орсон орлого	62873.4	64404.3	1530.9
Суурин телефон цэг	994	760	-234
Үүнээс: айл өрх	600	366	-234
ADSL интернэтэд холбогдож буй ААНБ, айл өрх	311	336	25
КaTВ-ын хэрэглэгчдийн тоо	2904	2858	-46



буюу 234 хэрэглэгчээр буурсан байна.

Тайлант хугацаанд суурин телефон хэрэглэгчдийн тоо 760, кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо 2858, ADSL интернет ашиглах эрхээр интернетэд холбогдож буй байгууллага, айл өрхийн тоо 336-д хүрсэн байна. Нийт суурин телефон хэрэглэгчдийн 48.2 хувь буюу 366 нь айл өрхийн хэрэглэгчид байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 39.0 хувиар

2014 оны 1-р улиралд шуудангийн үйлчилгээний салбар 3006 ширхэг бичиг захидал, 218 ширхэг илгээмж, 33.0 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.


ЭРҮҮЛ МЭНД: Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2014 оны эхний улиралд 222 эх амаржиж, 225 хүүхэд төрүүлснээс гадны 30 эх амаржсан байна.

Тайлант хугацаанд 66594 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 10114 хүнээр буюу 18.0 хувиар өссөн байна. Харин 1700 хүн хэвтэн эмчлүүлсэн байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 103 хүнээр буюу 5.7 хувиар буурсан байна.

Мөн энэ хугацаанд халдварт өвчний 82 тохиолдол гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 99 тохиолдлоор буюу 54.7 хувиар буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 29.6 болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 36.8 продицимилээр буурсан байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн халдварт өвчин

	Үзүүлэлт	2013 он	2014 он	өсөлт бууралт
Үүнээс	Халдварт паразит өвчин	103	62	-41
	Заг хүйтэн	36	16	-20
	Тэмбүү	26	22	-4
	Трихомноз	18	13	-5
	Сүрьеэ	15	7	-8
	Кандидоз	8	4	-4
Үүнээс	Цочмог халдварт өвчин	78	20	-58
	Цусан суулга	3	2	-1
	Гепатит А	12	2	-10
	Салхин цэцэг	9	13	4
	Гахайн хавдар	41	-	-41
	Гар хөл амны өвчин	1	3	2
	Нийт халдварт өвчин	181	82	-99





2014 оны эхний улирлын байдлаар халдварт паразит өвчин 62 болж нийт халдварт өвчний 75.6 хувийг эзэлж байна. Харин цочмог халдварт өвчин 20 байгаа нь нийт өвчний 24.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 58 тохиолдлоор буурсан байна.

ГЭМТ ХЭРЭГ: 2014 оны 1-р улиралд дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 68 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар буюу 3 хэргээр буурсан байна. Мөн хэрэг илрүүлэлт 76.5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.9 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм.



Хүснэгт 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2013 он	2014 он		
Хүн амь	1	-	-1	-
Хүчин	2	1	-1	1.5
Дээрэм	2	2	-	2.9
Танхай	4	5	1	7.4
ББМГУчруулах	30	28	-2	41.2
Ашиглах	1	-	-1	-
Хулгай	17	13	-4	19.1
<i>үүнээс: малын</i>	<i>2</i>	<i>1</i>	<i>-1</i>	<i>7.7*</i>
Булаалт	-	-	-	-
Залилан	2	-	-2	-
ХАБЭсрэг	4	5	1	7.4
Гал түймэр	-	-	-	-
Бусад	8	14	6	20.6
Бүгд	71	68	-3	100.0
Хэрэг илрүүлэлт	70.6	76.5		

*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувийг буюу 41.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг, 19.1 хувийг хулгайн хэрэг, 20.6 хувийг бусад хэргүүд, 7.4 хувийг танхайн хэрэг, 7.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2.9 хувийг дээрмийн хэрэг, 1.5 хувийг хүчингийн гэмт хэрэг тус тус эзэлж

байна. Тайлант хугацаанд хүний амь, ашиглах, залилан, булаалтын болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 12. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2013 он		2014 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүчин	1	-	-	1
Дээрэм	1	1	2	1
Танхай	4	3	4	1
ИЭЧЭМЭ	21	3	16	7
Хулгай	2	2	1	-
Залилан	-	1	-	-
ХАБЭсрэг	1	-	1	-
Бусад	2	2	4	5
Бүгд	32	12	28	15
Дүнд эзлэх хувь	45.1%	16.9%	41.2%	22.1%



2014 оны 1-р улирлын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 28 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар буюу 4 хэргээр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 41.2 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 3.9 пунктээр буурчээ.

Харин гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 15 болж өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувиар буюу 3 хэргээр өссөн бөгөөд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 22.1 хувийг эзэлж байгаа нь өнгөрөгч оноос 5.2 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд гэмт хэрэгт 78 иргэн холбогдон шалгагдсаны 1.3 хувь буюу 1 нь 18 хүртэлх насны хүүхэд, 15.4 хувь буюу 12 нь эмэгтэйчүүд байна.




Хүснэгт 13. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	72	78	6	8.3
Үүнээс: эмэгтэйчүүд	14	12	-2	-14.3
хүүхэд	2	1	-1	-50.0
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	73	76	3	4.1
Үүнээс: нас барсан	3	1	-2	66.7
гэмтсэн	41	48	7	17.1
Эрүүлжүүлэгдсэн хүний тоо	471	448	-23	-4.9
Баривчлагдсан хүний тоо	30	37	7	23.3
Учирсан хохирол /сая төгрөг/	62.8	31.4	31.4	-50.0
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	15.1	15.3	0.2	1.3

Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас 76 хүн хохирсон бөгөөд 48 хүн гэмтэж, 1 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс гэмтсэн хүний тоо 4.1 хувиар буюу 3 хүнээр өссөн бол нас барсан хүний тоо 2 хүнээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 31.4 сая төгрөгийн хохирол учирсны 48.7 хувийг буюу 15.3 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Энэ оны 1-р улиралд 448 хүн эрүүлжүүлэгдэж, 37 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 4.9 хувиар буюу 23 хүнээр буурч, баривчлагдсан хүний тоо 23.3 хувиар буюу 8 хүнээр нэмэгдсэн байна.


Зураг 13. Гэмт хэрэгт холбогдсон иргэд



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД:

2014 оны 3 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 256 байгаа нь энэ оны өмнөх сараас 28.3 хувиар буюу 101 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэн 132 байгаа нь өмнөх сараас 33.7 хувиар буюу 67 хүнээр тус тус буурсан байна. Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 33 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 69.7 хувь нь буюу 23 нь эмэгтэйчүүд эзэлж байна. Тайлант хугацаанд 32 иргэн ажилд зуучлуулан орж, 17 иргэн бүртгэлээс хасагдсан байна.


Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн ажилд орсон байдлыг авч үзэхэд:

- төсөвт, төрийн байгууллага–14
- хувьцаат компани–4
- хязгаарлагдмал хариуцлагатай компани–14 хүмүүс тус тус ажилд орсон байна.

Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэн /насны бүлгээр/



2014 оны 3-р сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 24.6 хувь нь 16-24 насны, 37.5 хувь нь 25-34 насны, 21.0 хувь нь 35-44 насны, 16.8 хувь нь 45-60 насны ажилгүйчүүд эзэлж байна.

Тайлант сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүйчүүдыг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 31.3 хувийг дээд, 6.6 хувийг тусгай дунд, 7.0 хувийг мэргэжлийн анхан шатны, 43.8 хувийг бүрэн дунд, 7.8 хувийг бүрэн бус дунд, 1.6 хувийг бага боловсролтой, боловсролгүй ажилгүйчүүд 1.6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 16. Ажилгүй иргэд боловсролын түвшингээр




ҮНЭ ХАНШ: Хүнсний өргөн хэрэглээний 19 төрлийн бүтээгдэхүүний үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 бүтээгдэхүүний үнэ тогтвортой, 3 бүтээгдэхүүний үнэ буурсан, 12 бүтээгдэхүүний үнэ өссөн, 1 төрлийн бүтээгдэхүүн энэ сард худалдаанд гараагүй байна.

Хүснэгт 14. Өргөн хэрэглээний барааны дундаж үнэ /жил бүрийн 3 сар/


Барааны нэр төрөл	Х\н	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	<u>2014%</u> 2013
1. Гурил /дээд/	кг	680	955	950	951	1100	115.7
2. Гурил 1-р зэрэг /алтан тариа/	кг	555	728	750	765	765	100.0
3. Гурил 2-р зэрэг /алтан тариа/	кг	520	575	525	585	600	102.6
4. Цагаан будаа	кг	1375	1625	1600	1650	2200	133.3
5. Шар будаа	кг	1075	1850	1500	1450	1500	103.4
6. Хонины мах	кг	4000	4038	7694	7320	7750	105.9
7. Үхрийн мах	кг	4488	4628	8275	8235	9300	112.9

8. Сүү	л	1063	1100	1350	1450	1425	98.3
9. Тараг	л	1300	1450	-	1533	-	-
10. Цөцгийн тос	кг	3500	2700	3000	3000	3100	103.3
11. Элсэн чихэр	кг	1600	1625	1638	1600	1600	100.0
12. Монгол төмс	кг	860	813	900	700	900	128.6
13. Монгол байцаа	кг	1000	963	988	1200	1200	100.0
14. Монгол лууван	кг	838	925	888	800	1350	168.8
15. Манжин	кг	813	1375	900	1000	1500	150.0
16. Хятад бөөрөнхий сонгино	кг	1175	950	988	1500	1300	86.7
17. Монгол сонгино	кг	1975	1500	2500	2980	1650	55.4
18. Ургамлын тос	ш	2588	2712	2850	3075	3575	116.3
19. Өндөг	ш	231	225	270	265	350	132.1

Зураг 17. Монгол төмс /нэг кг/



Зураг 18. Монгол лууван /нэг кг/




Хүснэгт 15. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2014 оны 3 сарын долоо хоногоор

Хүнсний бараа		х.н	03.07	03.14	03.21	03.28	$\frac{03.28}{03.21} \times 100\%$
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1100	1100	1100	1100	100.0
	I зэрэг	кг	765	765	765	765	100.0
	II зэрэг	кг	600	600	600	600	100.0
Будаа	цагаан	кг	2200	2200	2200	2200	100.0
	шар	кг	1500	1500	1500	1500	100.0
Хонины мах	ястай	кг	7000	7000	7500	7500	100.0
	цул	кг	8000	8000	8500	8500	100.0
Үхрийн мах	ястай	кг	8500	8500	8500	8500	100.0
	цул	кг	9700	9700	10500	10500	100.0
Адууны мах, ястай		кг	6500	6500	7000	7000	100.0
Ямааны мах		кг	6000	6000	6000	6000	100.0
Элсэн чихэр		кг	1600	1600	1600	1600	100.0
Сүү		литр	1500	1400	1400	1400	100.0
Тараг		литр	-	-	-	-	-
Цөцгийн тос, Орос		кг	3100	3100	3100	3100	100.0
Байцаа		кг	1200	1200	1200	1200	100.0
Манжин		кг	1500	1500	1500	1500	100.0

Төмс	монгол	кг	700	700	1100	1100	100.0	
Лууван	монгол	кг	1200	1200	1500	1500	100.0	
Сонгино	хятад	кг	1400	1400	1200	1200	100.0	
бөөрөнхий	монгол	кг	1800	1800	1500	1500	100.0	
Сармис, булцуу		кг	200	200	200	200	100.0	
Огурцы, хятад		кг	5000	5000	4500	4500	100.0	
Помидор, хятад		кг	5000	5000	5500	5500	100.0	
Ургамлын тос		ш	3575	3575	3575	3575	100.0	
Өндөг		ш	350	350	350	350	100.0	
Талх	буриад	том 900г	ш	1050	1050	1050	1050	100.0
		дунд 700г	ш	950	950	950	950	100.0
		жижиг 500г	ш	800	800	800	800	100.0
		Есөн шанд	ш	900	900	875	875	100.0
		Атар талх	ш	850	850	850	850	100.0

Зураг 19. Нэг кг махны үнэ /жил бүрийн 3 сар/



Хүснэгт 16. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрх	ААНБ
Дулаан	1 м ³ =341 төг	1м ³ =697 төг
Халуун ус	1 хүн=1924 төг /зун/ 1 хүн=1282 төг /өвөл/	1гкал=41147 төг
Цэвэр ус	1хүн=3243 төг 1м ³ =400 төг /тоолууртай/	1м ³ =590 төг /тоолууртай/ 1м ³ =640 төг /тоолуургүй/
Бохир ус	1хүн=2967 төг 1м ³ =360 төг /тоолууртай/	1м ³ =590 төг /тоолууртай/ 1м ³ =650 төг /тоолуургүй/

Хүснэгт 17. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
• Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
<i>Энгийн тоолууртай</i>		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	79.0

Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	96.6
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	84.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	60.0
Сарын суурь тариф		
• Аж ахуйн нэгж, байгууллага	төг/сар	1000.0
Энгийн тоолууртай		
	төг/квт.ц	105.6
3 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	105.6
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	178.6
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	60.0

Хүснэгт 18. Түлш, шатахууны үнэ /3 сарын байдлаар/

Д/д	Шатахууны нэр төрөл	2013 он	2014 он	өөрчлөлт	
				хувь	төгрөгөөр
1	АИ - 80	1574	1540	2.2	-34
2	АИ - 92	1710	1700	0.6	-10
3	Дизель түлш	1840	1830	0.5	-10

Түлш, шатахууны 2014 оны 3-р сарын дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд литр тутамдаа АИ-80 бензин 2.2 хувиар буюу 34 төгрөгөөр, АИ-92 бензин 0.6 хувиар буюу 10 төгрөгөөр, дизель түлш 0.5 хувиар буюу 10 төгрөгөөр тус тус буурсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2014 оны 4 дүгээр сарын 9